



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2019 оны 08 сарын 29 өдөр

Дугаар 359

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3, 269 дүгээр тогтоолын 2, 3 дугаар заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 46,866,001.23 (дөчин зургаан сая найман зуун жаран зургаан мянга нэг төгрөг хорин гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг нээлттэй дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Мөнхбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Ажлын хэсэг байгуулж хавсралтад заасан автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр зохих захиргааны актын дагуу төрийн өмчит үйлдвэрийн газрын дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт болон хөрөнгийн үнийг байгууллагын дансанд төвлөрүүлсэн баримтын хамт 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
TYP ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
TYP ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЭРДЭНЭБАЯР

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2019 оны дугаар сарын 12-ны өдрийн
... дугаар тогтооны хавсралт

**"МОНГОЛРОСЦВЕТМЕТ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААР ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/Д	Хөрөнгийн нэр, дугаар	Үйлд-сэн/ Ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуриимтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Суудлын автомашин BMW (Москва дахь Төлөөлгөгчийн газар) улсын дугаар 089D16377, арлын дугаар WBANU110X0CW41408	2006/2007	46,866,001.23	46,866,001.23	0.00	10,000,000.00
	ДҮН		46,866,001.23	46,866,001.23	-	10,000,000.00
			(Дөчин зургаан сая найман зуун жаран зургаан мянга нэг төгрөг хорин гурван мөнгө)	(Дөчин зургаан сая найман зуун жаран зургаан мянга нэг төгрөг хорин гурван мөнгө)		(арван сая)